



**“ТҮМЭН ШУВУУТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭ**

**Улаанбаатар
2022 он**



1. Үнэлгээний зорилго

- 1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.
- 1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТҮЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.
- 1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилдтооцно.
- 1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.
- 1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТҮЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	11		
2	ТҮЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	8		
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6		
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	4		
5	Эрсдэлийн удирдлага	8	5		
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4		
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		
8	Компанийн соёл	6	4		
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		
	Нэгдсэн дүн	72	60		

3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилгоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

3.2.1. авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;

- 3.2.2.70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3.50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4.49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

4. Үнэлгээний асуулга

“Түмэн шувуут” ХК

/нэр/

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Он оо	Хувь
1	<i>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</i>	ТУЗ-ийн 2019 оны 05 сарын 15-ны өдөр 05/2019 тоот тогтоолоор баталсан ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тус бүрт нь тусгаж өгсөн.	Энэхүү журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарын чиг үүргийг тодорхой тусгаж, мөрдөж ажилладаг.	2	100
2	<i>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж өгсөн. Уг журмын 3, 4-р зүйлд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх асуудлыг тус бүрт нь тусгасан. www.tumenshuvuut.mn	ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлаар батлагдсан журамд тусгагдсан зарчмыг баримтлан ажилладаг.	2	100
3	<i>1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.</i>	Уг тайланг жил бүр Нэр дэвшүүлэх хорооны хурлын дүгнэлтээр гаргаж ТУЗ-ийн хуралд танилцуулдаг.	Энэ тайланг цахим хуудаст байршуулаагүй. Цаашид тусад нь цэс нэмж байрлуулна. www.tumenshuvuut.mn	1	50
4	<i>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд дэргэдэх хороодын чиг үүрэг бүтэц бүрэлдэхүүн мэргэжил, ур чадварыг заасан байдаг. ТУЗ болон түүний дэргэдэх хороод журамд заасан шаардлагын дагуу үйл		2	

	<i>тэнцвэрт байдал зэргийг тусгана.</i>	ажиллагаагаа хэвийн явуулж ирсэн. www.tumenshuvuut.mn			
5	<i>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.</i>	Шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүдийг компанийн үйл ажиллагаатай танилцуулах, чиглүүлэх ажил хийгддэг. 2019, 2020, 2021 онуудад компанийн үйл ажиллагаатай танилцах ажлыг зохион байгуулж байсан. Шаардлагатай сургалт мэдээллээр хангаж ажилладаг	Сургалтад ТУЗ-ийн зарим гишүүд хамрагдсан. ТУЗ-ийн НБДарга Ахисан түвшний сургалтанд хамрагдаж байсан. Гишүүдийг хамруулах ажлыг цаашид үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2	100
6	<i>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</i>	ТУЗ-ийн НБД-ыг ТУЗ-ийн дарга санал болгож ТУЗ-ийн хурлаас томилдог. Хурал болон дэргэдэх хороодын хурлын төлөвлөгөөг гаргаж, цаг тухайд нь хурал зохион байгуулах, тайлан мэдээ илгээх, бичиг хэрэг хөтлөх ажлыг хариуцан ажиллаж байгаа.		2	100
ДҮН				11	
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	<i>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу 9 гишүүнээс хараат бус 3 гишүүнтэй. Хараат бус гишүүд нь дэргэдэх хороодын даргын үүргийг гүйцэтгэнэ. Дэргэдэх хороодын 3-ны 2 нь хараат бус гишүүн байдаг. Хараат бус гишүүд журмын дагуу ажиллуулж байгаа.		2	100
8	<i>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.</i>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан. Аудитын хорооны дарга ТУЗ-ин хараат бус гишүүн байдаг. Хуралд зөвхөн Аудитын хорооны гишүүд болон ТУЗ нарийн бичиг оролцдог. Шаардлагыг хангаж ажиллаж байна.		2	100

9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж оруулсан. Хорооны дарга нь Хараат бус гишүүн байдаг.	Гүйцэтгэх удирдлага өөрөө тус хорооны гишүүн байдаг. Энэ асуудлыг ТУЗ-ийн 2022 оны 09-р сард хуралдах ээлжит хурлаар засах шаардлагатай болов.	1	50
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгаж оруулсан. Хорооны дарга нь Хараат бус гишүүн байдаг. Шаардлагыг ханагж ажиллаж байна.		2	100
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.		2021 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Мүүри аудит ХХК-ийн зөвлөмжийн хүрээнд 2022 оны 3-р улиралд хуралдах ТУЗ-ийн ээлжит хуралд Ёсзүйн хороо байгуулах, холбогдох баримт бичгийг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	1	50
ДҮН				8	
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн 2019 оны 05-р сарын 15-ны 05/2019 тоот тогтоолоор баталсан ТШ ХК-ийн мэдээллийн үйл ажиллагааны журам баталсан. Журмын дагуу Зохицуулах хороо, Бирж болон компанийн цахим хуудаст www.tumenshuvuut.mn сайтад мэдээлэл тайланг нээлттэй тавьдаг.		2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг	Компанийн засаглалтай холбоотой дүрэм, журмууд нээлттэй		2	100

	<i>цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</i>	байршуулдаг. Компанийн дүрэм 1. Түмэн шувуут ХК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 2. Мэдээллийн үйл ажиллагааны журам 3. Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, соинрхлын зөрчлийг зохицуулах журам 4. ХЭХ-ын зар хүргэх журам			
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Санхүүгийн тайлан болон санхүүгийн бус тайлан мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол холбогдох байгууллагууд болон компанийн www.tumenshuvuut.mn сайтад нээлттэй тавьдаг. Томоохон хөрөнгө оруулалтын төслүүд дээр байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэж, цахим хуудсандаа байршуулдаг.	Томоохон хөрөнгө оруулалтын төсөл, түүний болзошгүй эрсдэлийн үнэлгээг ТУЗ-ын хурлаар хэлэлцүүлж байж шийдвэр гаргадаг.	2	100
ДҮН				6	100
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгахдаа эдгээр үүргийг оруулсан байгаа. Журмын дагуу Аудитын хороо үйл ажиллагаагаа явуулдаг.		2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хувьцаа эзэмшигч-дийн ээлжит хуралд Аудитын хороо хөндлөнгийн аудитын дүгнэл-тийг тараах материал болон ажлын тайланд тусгаж танилцуулж ирсэн.	Цаашид Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хөндлөнгийн аудитороор мэдээлэл өгүүлэхээр төлөвлөж байгаа.	1	50
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.	Компани нь дотоод аудитын нэгжийг 2022 оны эхний хагас жилд байгуулах үүрэг даалгаварыг 2022 оны 03-р сарын 14-ний өдрийн ТУЗ-өөс авсан	Одоогоор нэгж байгуулах, журам, баримт бичиг батлах үйл ажиллагаа төслийн хүрээнд хэлэлцэгдэж байгаа болно.	1	50
ДҮН				4	
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					

18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Гүйцэтгэх удирдлагын тайлан болон санхүүгийн мэдээлэлд үндэслэн ТУЗ хяналт тавьж байна.	Эрсдлийн удирдлагын заавар бүтэц одоогоор байхгүй байгаа.	1	50
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.</i>	Компанид одоогоор эрсдлийн удирдлагын хороо байхгүй байгаа боловч шийдвэр гаргалтын эрсдэлийн асуудлыг ТУЗ-ийн хурлаар тухай бүр хэлэлцдэг.	2021 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Мүүри аудит ХХК-ийн зөвлөмжийн хүрээнд 2022 оны 3-р улиралд хуралдах ТУЗ-ийн ээлжит хуралд Эрсдлийн удирдлагын хороо байгуулах, холбогдох баримт бичгийг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	1	50
20	<i>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.</i>	Компани нь байгаль орчны үнэлгээг жил бүр хийж тайлагнадаг. Ерөнхий үнэлгээг холбогдох байгууллагаар хийлгэж, олон нийтэд www.tumenshuvuut.mn сайтаар мэдээлдэг. Шувууны аж ахуйн үйл ажиллагаанд 2021 онд нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн. Гүйцэтгэгч байгууллага: Цагаануулын оргил ХХК		2	100
21	<i>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Одоогоор тус компани мөрдөж буй бодлого, төлөвлөлт, дүрэм, журмын хүрээнд комплайнсын хяналтыг зохицуулж байна	Комплайнсын засаглалыг хэрэгжүүлэх зарим бүтцийг байгуулна.	1	50
ДҮН				5	
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	<i>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</i>	ХЭХ-д ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, давтамжийг баталдаг. Энэ талаар хувьцаа эзэмшигчдэд зох журмын дагуу мэдээлэл өгдөг. www.tumenshuvuut.mn		2	100

23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Одоогоор энэ талаар тусгайлсан баримт бичиг байхгүй боловч холбогдох журмаар	Цаашид боловсруулан хэрэгжүүлэх болно.	1	50
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Энэ тухай тайланд ерөнхий байдлаар тусгадаг.	Шалгуурыг тодорхой тусгаагүй байгаа.	1	50
ДҮН				4	
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлднэ.	Компанийн дүрэмж, журамд бусад оролцогч талуудтай харилцахад баримтлах зарчмууд тусгагдсан бөгөөд мөрдөж ажилладаг. Ажилтан, харилцагч, нийлүүлэгч, зээлдүүлэгч нартай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллаж тогтсон		2	100
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Тайланд энэ тухай тусгадаг. Ихэвчлэн зорилт үр дүнгээ дэлгэрэнгүй тусгаж оруулдаг. Энэ асуудлыг хоёр талын гэрээгээр зохицуулж ирсэн.		2	100
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	https://www.facebook.com/tumenshuvuut болон http://tumenshuvuut.mn/ цахим хуудсуудад тогтмол мэдээлэл байршуулж ажилладаг.		2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Ажилтнуудын санал хүсэлтийг www.timely.mn системээр дамжуулан авч эхэлсэн. Өмнө нь өргөдөл хэлбэрээр авдаг байсан. Ажилтнуудыг чадавхжуулахад чиглэсэн сургалтуудыг гадны байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлдэг.		2	100
ДҮН				8	100
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					

29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	2019 оноос Компанийн философиог тодорхойлж www.tumenshuvuut.mn сайтаар дамжуулж нийтэд нээлттэй тавьсан. Ёсзүйн дүрэм байхгүй боловч Компанийн үнэт зүйлсэд тусгасны дагуу ёсзүйтэй, хариуцлагатай, шударга байхад чиглэн ажилладаг.	2021 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Мүүри аудит ХХК-ийн зөвлөмжийн хүрээнд 2022 оны 3-р улиралд хуралдах ТУЗ-ийн ээлжит хуралд Ёсзүйн хороог байгуулах, холбогдох баримт бичгийг батлуулан ажиллана.	2	100
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>	Одоогоор ийм тогтолцоо байхгүй байгаа.	Цаашид холбогдох хуулийн дагуу шүгэл үлээгчийн тогтолцоог бүрдүүлэхийг зохино.	1	50
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>	Ёсзүйн дүрэм одоогоор байхгүй байгаа боловч энэ зарчмыг баримтлан ажилладаг.	2021 оны санхүү, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийсэн Мүүри аудит ХХК-ийн зөвлөмжийн хүрээнд 2022 оны 3-р улиралд хуралдах ТУЗ-ийн ээлжит хуралд танилцуулахаар Ёсзүйн дүрмийн төслийн баримт бичгийг батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	1	50
ДҮН				4	
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	www.tumenshuvuut.mn сайтад компанийн санхүүгийн мэдээлэл, бүтэц зохион байгуулалтыг ХЭ-дэд нээлттэй мэдээлдэг.	Энэ шаардлагыг ханган биелүүлж ажиллаж байна.	2	100
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба</i>	Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хүрээнд Хувьцаатай	Энэ шаардлагыг ханган биелүүлж ажиллаж байна.	2	100

	<i>тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>	өндөг хөтөлбөрийг зохион байгуулж, http://tumenshuvuut.mn/хувьцаатай-өндөг цахим сувгийг тогтмол ажиллуулж байна.			
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	ХЭ-ийг хуралд оролцох, саналаа өгөх боломжийг биеэр болон онлайнгаар, зайнаас оролцох системийн тусламжтайгаар бүрэн хангадаг. Энэ асуудлыг холбогдох журмын дагуу мөрдөж ажилладаг	Энэ шаардлагыг ханган биелүүлж ажиллаж байна.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Ийм асуудал одоогоор үүсээгүй байгаа. Шаардлага гарвал журмын дагуу ажиллана.		2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Уг журмыг 2019 оны 05-р сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар баталж байгаа. Өнөөдрийн байдлаар ийм хэлцэл хийгдээгүй болно. Шаардлага гарвал журмын дагуу биелүүлэх болно.		2	100
ДҮН				10	100
НЭГДСЭН ДҮН				60	83,3%

Үнэлгээ хийсэн:

- ТУЗ-ийн Хараат бус гишүүн:

 /А.Бакей/

- ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга:

 /Б.Нямбаяр/

-оОо-